

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ *19/43*

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн үр дүнг баталж, урамшуулал тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.9, 76.1.18 дахь хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.5.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.9.1 дэх хэсэг болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 19/41 тоот тогтоолын 2 дугаар хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Гүйцэтгэх захирал Булганы Гантулга нь 2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрөөс Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулан Конрактын гэрээг дуусгавар болгосон үр дагаврыг зохицуулах асуудлаар түүнтэй хэлцэл хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох гэрээ байгуулах эрхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
2. Б.Гантулгатай дээр заасан хэлцэлийг байгуулсны үндсэн дээр түүний үндсэн цалинг Конрактын гэрээ дуусгавар болсноос хойш 3 (гурав) сарын хугацаанд олгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ 19/44

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ТУЗ-ийн Аудитын хорооны бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай.
Үүнд:

Хорооны дарга: Ж.Жаргалсүрэн;

Гишүүд: С.Боргил;

Н.Цэвэгмид.

2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам, холбогдох бусад баримт бичгийг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн аудитын хорооны бүрэлдэхүүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудаст байршсан мэдээлэлд өөрчлөлт оруулах, Санхүүгийн Зохицуулах хороо болон олон нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар), ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг) нарт үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ 19/45

Улаанбаатар хот

Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.10 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6.5 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн 18/16 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан бүтцийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулах, алба, хэлтэс, нэгж, албан тушаалтныг удирдлагаар ханган, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
4. Компанийг төлөөлж холбогдох бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг холбогдох албан тушаалтанд өөрийн эрх хэмжээний дотор олгож ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т зөвшөөрсүгэй.
5. Компанийн өдөр тутмын мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх, төлбөрийн баримтад гарын үсэг зурах эрхийг холбогдох албан тушаалтанд олгохыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д зөвшөөрсүгэй.





ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ 19/46

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан ГОЛОМТ банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.

Зээлийн хэмжээ	3 (гурав) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Зээл, зээлийн шугам
Зээлийн хугацаа	2 хүртэл жил
Зээлийн хүү, шимтгэл	- Сарын 1,5 хувиас ихгүй; - Зээлийн хүүг жил бүр хянах, тохиролцох нөхцөлтэй; - Зээлийн үйлчилгээний шимтгэл 0,5%; - Нөөцлөн баталгаажуулах шимтгэл жилийн 3,6 хувиас ихгүй.
Барьцаа хөрөнгө	“ЛэндМН ББСБ” ХК-ийн зээлийн багц буюу шаардах эрх /Банктай тохиролцсон нөхцлийн дагуу/

2. Зээл авах асуудлаар ГОЛОМТ банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
3. ГОЛОМТ банктай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй Компанийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

/О.БОЛДБААТАР/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/В.БАЯРСАЙХАН/

/С.БОРГИЛ/

/Н.ЦЭВЭГМИД/

/Ч.НОМИН/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ 19/47

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.

Зээлийн төрөл	Хадгаламж барьцаалсан зээл
Хадгаламжийн хэмжээ	600,000 (зургаан зуун мянга) ам.доллар
Зээлийн хэмжээ	Хадгаламжийн 110 (зуун арав) хувьтай тэнцэх хүртэл хэмжээний төгрөг
Зээлийн хугацаа	2 хүртэл жил
Зээлийн хүү	Жилийн 15.6 (арван тав аравны зургаа) хувь хүртэл
Барьцаа хөрөнгө	Нэмэлтээр ЛэндМН ББСБ ХК-ийн 300,000,000 төгрөгийн хэвийн зээлийн багц

2. Зээл авах асуудлаар ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
3. ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН банкт байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй Компанийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

/С.ЭНХ-АМГАЛАН/

/С.БОРГИЛ/

/Ч.НОМИН/

/В.БАЯРСАЙХАН/

/Н.ЦЭВЭГМИД/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ ... 19/48

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан КАПИТРОН банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.

Зээлийн хэмжээ	3 (гурав) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Зээл, зээлийн шугам
Зээлийн хугацаа	2 хүртэл жил
Зээлийн хүү, шимтгэл	- Сарын 1,5 хувиас ихгүй; - Зээлийн хүүг жил бүр хянах, тохиролцох нөхцөлтэй; - Зээлийн үйлчилгээний шимтгэл 0,5%-аас ихгүй.
Барьцаа хөрөнгө	“ЛэндМН ББСБ” ХК-ийн зээлийн багц буюу шаардах эрх /Банктай тохиролцсон нөхцлийн дагуу/

2. Зээл авах асуудлаар КАПИТРОН банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
3. КАПИТРОН банктай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй Компанийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

/О.БОЛДБААТАР/

/В.БАЯРСАЙХАН/

/Н.ЦЭВЭГМИД/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/С.БОРГИЛ/

/Ч.НОМИН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ 19/49

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан УЛААНБААТАР банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.

Зээлийн хэмжээ	3 (гурав) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Зээл, зээлийн шугам
Зээлийн хугацаа	2 хүртэл жил
Зээлийн хүү, шимтгэл	- Сарын 1,5 хувиас ихгүй; - Зээлийн хүүг жил бүр хянах, тохиролцох нөхцөлтэй; - Зээлийн үйлчилгээний шимтгэл /Банкны ерөнхий нөхцлийн дагуу/.
Барьцаа хөрөнгө	“ЛэндМН ББСБ” ХК-ийн зээлийн багц буюу шаардах эрх /Банктай тохиролцсон нөхцлийн дагуу/

2. Зээл авах асуудлаар УЛААНБААТАР банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т олгосугай.
3. УЛААНБААТАР банктай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй Компанийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

/О.БОЛДБААТАР/

/С.ЭНХ-АМГАЛАН/

/В.БАЯРСАЙХАН/

/С.БОРГИЛ/

/Н.ЦЭВЭГМИД/

/Ч.НОМИН/

/Ж.ЖАРГАЛСҮРЭН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр

№ ... *19/50*

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны чиглэл нэмэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1, 9.6.22 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.6.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх гэсэн үйл ажиллагааг нэмсүгэй.
2. Компанийн шинээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон бусад эрх бүхий байгууллагаас авах ажлыг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-т үүрэг болгосугай.

